

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА

/2023 оны жилийн эцсийн байдлаар /

2024.02.07

Дархан-Уул

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийг хяналтанд авсан зүйл, заалттай харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, үүрэг болгосон зүйл, заалтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд үнэлгээний зорилго оршино.

Хяналтанд авсан Монгол Улсын хууль, УИХ-ын тогтоол, УИХ-ын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсон “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим систем буюу new.unelgee.gov.mn –ийн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн цэсэнд байршсан 108 шийдвэрийн 200 заалт, Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэж ирүүлсэн тайланг уншин гүйцэтгэв.

Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга нарын 2024.02.05-ны өдрийн хурлын гишүүдээс өгсөн санал, Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Хууль эрх зүйн хэлтэс, Нийгмийн бодлогын хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газраас ирүүлсэн нэмэлт мэдээлэл, Засгийн газрын гишүүнтэй 2023 онд байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн статистик тоо баримтад үндэслэн сайжруулалтыг 2 удаа гүйцэтгэлээ.

Хяналтанд авсан шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхдээ “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6 дугаар бүлгийн 6.3 дахь заалтын дагуу 5 шатлалт арга зүйгээр, шийдвэрийн зүйл, заалтын гүйцэтгэлийн үр дүнг хүрэх түвшин буюу тавьсан зорилтод харьцуулан хувиар тооцож гаргалаа.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, үр дүн

2023 оны жилийн эцсийн байдлаар аймгийн Засаг дарга хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

- ✓ Монгол Улсын 12 хуулийн 31 заалт,
- ✓ УИХ-ын 4 тогтоолын 10 заалт,
- ✓ УИХ-ын байнгын хорооны 17 тогтоолын 44 заалт,
- ✓ Монгол Улсын Ерөнхийлөгчийн 5 зарлигийн 11 заалт,

- ✓ ҮАБЗ-ийн 4 зөвлөмжийн 8 заалт,
- ✓ Засгийн газрын 31 тогтоолын 42 заалт,
- ✓ Засгийн газрын хуралдааны 33 тэмдэглэлийн 50 заалт,
- ✓ Засгийн газрын 2 албан даалгаврын 4 заалт,

нийт 108 шийдвэрийн 200 заалтыг хяналтанд авч, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

2023 онд цахим санд байршсан заалтын тоо, хугацаанд нь системд байршуулсан баталгаажуулсан байдал, үнэлгээг харуулбал:

Хугацаа	Заалтын тоо	Системд баталгаажуулсан хугацаа	Үнэлгээ
2023 оны 2 сар	30	III/03	60.88%
2023 оны 3 сар	138	III/08 /яаралтай горим/	93.36%
2023 оны 3 сар	31	IV/10	72.00%
2023 оны 4 сар	32	V/10	72.81%
2023 оны 5 сар	33	VI/09	78.18%
2023 оны 6 сар	146	VII/10/ эхний хагас жил/	87.97%
2023 оны 7 сар	50	VIII/09	82.00%
2023 оны 8 сар	50	IX/09	82.20%
2023 оны 9 сар	57	X/09	87.19%
2023 оны 10 сар	122	X/30 / яаралтай горим/	88.10%
2023 оны 10 сар	67	XI/09	83.88%
2023 оны 11 сар	81	XII/09	87.22%
2023 оны 12 сар	200	2024 оны 02 сарын 07-ны өдөр /2023 оны жилийн эцсийн/	90.55%
Нийт /давхардсан тоогоор/	1037	-	

Тайлант хугацаанд цахим санд 13 удаа байршсан (давхардсан тоогоор) 1037 заалтын хэрэгжилтийг ханган, цахим системд байршуулан, хугацаанд нь баталгаажуулан ажиллалаа. Үүнээс: Хяналт хэрэгжүүлэх газраас өгсөн үүрэг чиглэлийн дагуу тайлант хугацаанд яаралтай горимоор 2021, 2022, 2023 оны Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг 3 сар, Хууль, УИХ-ын тогтоол УИХБХ-ны тогтоолын хэрэгжилтийг 10 сард тус тус тайлагнаж, системд хугацаанд байршуулан баталгаажуулан ажиллалалаа.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгээр 2023 оны жилийн эцсийн байдлаар **90.99%** хувийн хэрэгжилттэй **4.55** онооны үнэлгээтэй байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад / 2022 онд 89.60% буюу 4.48 оноо/ 1.39%-иар өссөн байна.

Холбогдох шийдвэрийн төрөл тус бүрээр харуулбал:

№	Үнэлгээ	Нийт	Шийдвэр, төрөл								
			Монгол Улсын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	ҮАБ-ын зөвлөлийн зөвлөмж	
1.	Хяналтанд авсан нийт шийдвэрийн тоо	108	12	4	17	5	31	33	2	4	
2.	Хяналтанд авсан нийт зүйл, заалтын тоо	200	31	10	44	11	42	50	4	8	
3.	Үүнээс	Бүрэн хэрэгжсэн 100% (90-100%)	128	26	7	28	5	28	28	2	4
		Хэрэгжих шатанд 70% (50-89%)	52	3	3	13	6	5	16	2	4
		Хэрэгжилт хангалтгүй 30% (10-49%)	1	-	-	-	-	1	-	-	-
		Хэрэгжээгүй 0% (0-9%)	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	19	2	-	3	-	8	6	-	-	
Хэрэгжилтийн ерөнхий дүн, хувь		90.99% буюу 4.55 оноо	96.90% буюу 4.84 оноо	91.0% буюу 4.55 оноо	90.49% буюу 4.52 оноо	83.64% буюу 4.18 оноо	93.53% буюу 4.67 оноо	89.10% буюу 4.45 оноо	85.0% буюу 4.25 оноо	85.0% буюу 4.25 оноо	

2023 оны жилийн эцсийн байдлаар хяналтад авсан Монгол Улсын 12 хуулийг нэршил, заалтын тоогоор нь танилцуулбал:

1. Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль / 2003.05.30/-3 заалт,
2. Ойн тухай /Шинэчилсэн найруулга/ 2012-05-17 Дугаар 2022.06.03 хуулийн 1 заалт,
3. Өрийн удирлагын тухай /2015.02.18/ хуулийн 1 заалт,
4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль / 2021-12-17 / -ийн 2 заалт,
5. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 хуулийн 10 заалт,
6. Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07. Дугаар 2019-01-01 хуулийн 1 заалт,
7. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ (2020-05-07) хуулийн 5 заалт,
8. Хоршооны тухай /Шинэчилсэн найруулга/ / 2021-05-06 / МУ-ын хууль 1 заалт,
9. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай / 2021-07-07 / МУ-ын хууль 1 заалт,
10. Төрийн хэмнэлтийн тухай / 2022-04-29 / МУ-ын хууль 3 заалт,
11. Үндэсний их баяр наадмын тухай /Шинэчилсэн найруулга/ / 2022-06-28 / МУ-ын хууль 1 заалт,
12. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2022-07-05 Дугаар 2023.01.01-ийн 2 заалт,

нийт 31 заалт-ыг хяналтад авч хэрэгжилтийг 96.90% -иар ханган ажилласан байна.

УИХ-ын тогтоол 91.0%, УИХ-ын байнгын хорооны тогтоол 90.49%, Засгийн газрын тогтоол 93.53%-ийн хэрэгжилттэй байгаа бол бусад шийдвэрүүдийг 83.64-89.10%-иар хэрэгжүүлэн ажиллалаа.

30%-иар үнэлэгдсэн 1 заалтын хувьд:

- Засгийн газрын тогтоол Дугаар 419 “4.Улаанбаатар хотын хэт төвлөрлийг бууруулах, хот, хөдөөгийн хөгжлийн зохистой тэнцвэрийг хангах зорилгоор Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ аймаг, нийслэлийн Багануур, Багахангай, Налайх дүүрэг хүн амынхаа тоог 20 хувиар, бусад аймаг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх бодлогын чиглэлийг баримталж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг...” –урт хугацаандаа хэрэгжих боломжтой заалт гэж үзлээ.

2017-2023 онуудад хяналтад авсан шийдвэрийн төрлийг харьцуулж харуулбал:

(тухайн жилийн эцсийн байдлаар)

Он	Заалт, тоо	Нийт шийдвэрийн төрөл, үүнээс									
		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж	Засгийн газрын тогтоол	Ерөнхий Сайдын захирамж	Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар	ЗГХЭГ-ын даргын тушаал
2017	107	0	0	3	4	3	58	0	27	12	0
2018	149	2	3	3	7	3	74	5	24	13	15
2019	99	1	1	3	2	0	60	4	16	8	4
2020	182	23	1	4	4	8	95	1	23	24	0
2021	152	27	2	4	10	15	67	1	26	0	0
2022	124	68	-	4	14	8	13	-	17	-	-
2023	200	31	10	44	11	8	42	-	50	4	-

Дээрх хүснэгтээс харахад тухайн жилд хяналтад авсан нийт заалтын:

2017 онд 58 буюу 54.20%

2018 онд 74 буюу 49.66%

2019 онд 60 буюу 60.60%

2020 онд 95 буюу 52.19%

2021 онд 67 буюу 44.07%

2022 онд 17 буюу 13.70%

2023 онд 42 буюу 21.0%-ийг Засгийн газрын тогтоол буюу асуудлыг хамтран хэлэлцэж шийдвэрлэх үндсэн дээр баталсан баримт бичгийн заалтууд эзэлж байна.

Гурав. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ /Зөвлөмж/

1. Хэрэгжилт хангалтгүй буюу 30%-иар үнэлэгдсэн 1 заалт, хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 19 заалт буюу 2023 оны 12 сард батлагдсан шийдвэрүүдийн хэрэгжилтийг хангуулахад бодлогын хэлтсүүд, хэрэгжүүлэгч агентлагууд уялдаа холбоотой ажиллах, мээгжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг зөвлөж байна.

Дөрөв. Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хяналтнаас хасаж, орон нутгийн хяналтад авахаар хүргүүлж буй санал:

Засгийн Газрын Хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2023 оны 01/561 тоот “Тайлан, зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлсэн, хүчингүй болсон, тогтмолжсон дараах 8 шийдвэрийн 8 заалтыг цахим системийн хяналтнаас хасуулж, тухай саналыг тайлбарын хамт тэмдэглэж, цахим санд баталгаажууллаа.

Хяналтнаас хасах саналтай заалтын тоог 2017-2022 онуудын мөн үетэй харьцуулж хүснэгтээр харуулбал:

Хасах санал	Шийдвэрийн тоо	Заалтын тоо
2017 он	12	15
2018 он	25	34
2019 он	18	21
2020 он	25	26
2021 он	5	6
2022 он	6	6
2023 он	8	8

Диаграммаар харуулбал:



Хасах саналтай заалтуудыг тайлбарын хамт дэлгэрэнгүйгээр харуулбал:

Шийдвэрийн ийн лс. ллгаал Залтын лслгаал	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжүүлэх заалт	Хэрэгжилтийн явц	Тайлбар	
9	24	8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;	8.4.11. худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;	<p>https://shilendans.gov.mn/organization/5645?group=6&for=55793&rf=1843&gm=5 Орон нутгийн өмчийн газрын 2022 оны үйл ажиллагааны үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд нийт хэрэгжүүлэх 11 үзүүлэлтийг 99,9 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжүүлсэн 2023 оны хагас жилийн байдлаар хэрэгжилтийг 70 хувийн гүйцэтгэлтэйгээр ханган ажиллаж байна. Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 01/4664 тоот Худалдан авах ажиллагааны 2022 оны хэрэгжилтийн тухай зөвлөмжийн дагуу цаашид авах арга хэмжээний хэрэгжилтийг сайжруулах талаар төсвийн Ерөнхийлөн захирагчийн харьяа 32 байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Дархан-уул аймгийн Төрийн аудитын газрын гүйцэтгэлийн аудитын тайланд 2022 оны худалдан авах ажиллагааны чиглэлээр ямар нэгэн зөрчил гараагүй болно. Төрийн аудитын газраас ирүүлсэн өмчийн харилцаатай холбоотой цаашид анхаарч ажиллах зөвлөмжийн биелэлтийг хангуулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p>	Хяналтаас хасах (ил тод байдлын шалгуур үзүүлэлттэй давхцацсан)
9	25	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01	8.6.13. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;	Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдтэй сумдын Засаг даргын Тамгын газар нь Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр бий болгох, тохижилт үйлчилгээний чиглэлээр Шарын гол сум 1 аж ахуйн нэгж, 1 бичил уурхайн нөхөрлөлтэй, Хонгор сум 9 аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг хангуулан ажиллаж байна. Энэхүү хамтран ажиллах гэрээний хүрээнд 12 төсөл арга хэмжээг 640,4 сая.төгрөгөөр хийж хэрэгжүүлэхээр харилцан тохиролцож хамтран ажилласан. Сумдын Засаг даргын Тамгын газар нь байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэхэд хамтран ажиллахаар байгуулсан гэрээнүүдийг дүгнэн ажиллалаа.	Ил тод байдлын шалгуур үзүүлэлттэй давхцацсан
			<p>https://darkhan.gov.mn/transparency/transparencyDetail/%d1%82%d1%83%d1%81%d0%b3%d0%b0%d0%b9-%d0%b7%d3%a9%d0%b2%d1%88%d3%a9%d3%a9%d1%80%d3%a9%d0%bb-%d1%8d%d0%b7%d1%8d%d0%bc%d1%88%d0%b8%d0%b3%d1%87%d1%82%d1%8d%d0%b9-%d0%b1%d0%b0%d0%b9%d0%b3%d1%83%d1%83</p>		

14	34	<p>"Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2016-04-14 Дугаар 2016 №34"</p>	<p>7. газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийг боловсронгуй болгох, бэлэн байдлыг хангах, гамшгийн аюулыг эрт зарлан мэдээлэх тогтолцоог өргөтгөх, улсын болон байгууллага, аж ахуйн нэгжийн нөөцийн удирдлага, чадавхыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэл, иргэд, олон нийтийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх;</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоол, Гамшгаас хамгаалах чадавхыг дээшлүүлэх, газар хөдлөлт, галын аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх зорилгоор төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус сургалтыг нийт 150 аж ахуйн нэгж, байгууллагад сургалтыг зохион явуулж 4200 гаруй хүнийг хамруулан ажилласан. Газар хөдлөлтийн гамшгийн аюулыг таниулах, болзошгүй гамшгаас хамгаалах иргэд, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэл хүргэж гамшиг ослын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор Дархан, Хонгор, Шарын гол, Орхон сумдын нутаг дэвсгэрт гамшгийн үед зарлан мэдээллийн дохиогоор нүүн шилжих, түр цугларах 22 цэгийг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газраас нарийвчлан гарган 2023 оны 06 дугаар сарын 16-ний 16 цагт Зарлан мэдээллийн дуут дохиогоор нийт 98 байгууллагын 56221 ажилтан, алба хаагч, иргэд хамрагдсан байна.</p>	<p>Чиг үүрэгт хамааралгүй</p>
19	45	<p>"Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл"-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ</p>	<p>3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах.</p>	<p>Гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх чиглэлээр "1 алба хаагч -1 өрх" хэсэгчилсэн арга хэмжээг 2023 оны 04 сарын 04-ний өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн хооронд зохион байгуулж байна. Тус арга хэмжээний хүрээнд эхний улирлын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн зөрчил гарган шүүхээр баривчлах шийтгэлээр шийтгүүлсэн нийт 64 иргэнд 2023.12.01-ний өдрийг хүртэл нэг бүрчилсэн хяналт тавихаар алба хаагчдад хуваарилан өгч, хоёрдугаар улирлын байдлаар шинээр 32 иргэнийг хяналтад авсан. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, эсхүл үйлдэгдэж болзошгүй нөхцөл байдлын талаар тус цагдаагийн газрын 7037-102, 70194284, 89370102 дугааруудад 24 цагаар иргэн, хуулийн этгээдээс гэмт хэрэг, зөрчлийн талаар санал гомдлыг тухай бүр нь хүлээн авч, материалжуулан шалгаж аюулын зэргийн үнэлгээ хийж, шалтгаан нөхцөлийг судлан тогтоож, хохирогч нартай утсаар холбогдон хууль эрх зүйн мэдээлэл, зөвлөгөө өгч гэмт хэрэг, зөрчил дахин үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх ажлыг үе шаттай зохион байгуулан хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг Дархан, Орхон, Хонгор, Шарын сумдын 26 хамтарсан багийн 104 гишүүд хамруулан зохион байгуулсан. Нийт 26 хамтарсан багуудын үйл ажиллагааг дэмжиж аймгийн ГХУСАЗСЗ-өөс үйл ажиллагааны зардалд 20,8 сая төгрөгийн санхүүжилтийг олгож байна. Жил бүр оны ажлаараа тэргүүлсэн 2 хамтарсан багийг дэд зөвлөлөөс шалгаруулан тус бүр 500,0 мянган төгрөг, хамтарсан багийн гишүүн багийн нийгмийн ажилтан 1, сургуулийн нийгмийн ажилтан 1-г шалгаруулан тус бүр 200,0 мянган төгрөгөөр урамшуулдаг. Мөн МУГХУСАЗСЗ-өөс хамтарсан багуудад 10,1 сая төгрөг олгоод байна.</p>	<p>Хяналтаас хасах (цаг хугацааны хувьд ач холбогдолгүй)</p>

21	47	"Чиглэл өгөх тухай 2020-12-16 Дугаар 2020 №10 БОХХААБХ"	1.1/. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2020 оны 07 дугаар тогтоолоор байгуулсан ажлын хэсгийн хяналт шалгалтын тайланг хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай: 1/ Мах экспортлогч үндэсний аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжиж, мах, махан бүтээгдэхүүнийг экспортолдог аж ахуйн нэгжүүдийн тоог нэмэгдүүлэх;	Дархан-Уул аймагт мах экспортлох 2, мал төхөөрөх 2 үйлдвэр байгаагаас 2023 оны эхэнд "Дархан маат фүүдс" ХХК нь БНХАУ улс руу дулааны аргаар боловсруулсан мах, Узбекистан улс руу үхрийн мах, БНИУ руу ангилж савласан хонины мах экспортолж байна. Өег гурил ХХК БНХАУ руу 20 тонн улаан буудайн гурил экспортолж нэр төрлийг нэмэгдүүллээ. Үр дүн: Узбекистан, БНХАУ руу адуу, үхэр, хонины мах экспортолсон. Улсын хэмжээнд мал төхөөрөх мах боловсруулах үйлдвэрүүдэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай ХХААХҮЯ-ны Салбарын Ерөнхий байцаагчийн 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр баталсан удирдамжийн дагуу сайдын зөвлөхөөр ахлуулсан ХХААХҮЯ, БОАЖЯ, ЭМЯ-ны салбарын хяналтын газар, Мал эмнэлэгийн ерөнхий газар хяналтын улсын /ахлах/ байцаагчид хамтарсан ажлын хэсэг 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр Дархан-Уул аймаг мал төхөөрөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Дархан маат фүүдс ХХК, Дархан эрдэнэ мах комбинат ХХК зэрэг 2 аж ахуйн нэгжид хяналт шалгалтыг хийж ажиллалаа. Шалгалтын 8.1.3-т дотоодтой мал төхөөрөх үйлдвэрлэлийг шалгах, нэгдсэн хяналтын хуудсаар шалгахад Дархан маат фүүдс ХХК нь 28,7%-тай, Дархан-Эрдэнэ мах комбинат 26,8%-тай буюу бага эрсдэлтэй үнэлэгдсэн байна.	Хяналтаас хасах (цаг хугацааны хувьд ач холбогдолгүй)
31	76	Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №03 БОХХААБХ	1.4/. Тусгай хамгаалалттай газар нутагт Нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын захирамжаар газар эзэмших, ашиглах эрх олгосон болон Нийслэлийн нутаг дэвсгэрт Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар газар эзэмших эрх олгосон асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлэж, газрын эрхийг гэрчилгээ олгох, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах;	Улсын тусгай хамгаалалттай газар Дархан-Уул аймагт байдаггүй.	Улсын тусгай хамгаалалтын газаргүй тул хасах
67	138	Нийслэл Улаанбаатар хотод Их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл "Метро" байгуулах тухай (2023 оны 484-р тогтоолоор өөрчлөлт орсон) 2023-11-22 Дугаар 2023_411	9. Энэ тогтоол гарсантай холбогдуулан нарийн мэргэжлийн зайлшгүй шаардлагатай ажилтан, албан хаагчийг түр хугацаагаар шилжүүлэн ажиллуулах, төслийн хэрэгжилтийг хангахтай холбоотой мэдээ, мэдээллийг цаг алдалгүй шуурхай гаргаж өгөх, судалгаа тооцоолол хийх зэрэг үйл ажиллагаанд эрхэлсэн салбар, чиглэлд хамаарах асуудлаар бүхий л талын туслалцаа, дэмжлэг үзүүлж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн удирдлагуудад тус тус үүрэг болгосугай.	Шаардлагатай мэдээлэл, судалгаа тооцоололд хамаарах асуудлаар хамтран ажиллахад бэлэн байна.	УБ-т метро баригдах тул

86	16 0	"2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58"	<p>XXI.5. . Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангасан дүнгийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун Засгийн газрын гишүүдэд танилцуулав.</p> <p>Үүнтэй холбогдуулан дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав:</p> <p>1. Отор нүүдлийн шилжилт, хөдөлгөөнийг мал эмнэлгийн үзлэгт хамрагдсан гарал үүслийн гэрчилгээг үндэслэх, тархвар зүйн асуумжийн дагуу зохион байгуулан ажиллах талаар аймаг, сумд хооронд гэрээ байгуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг бүх шатны Засаг дарга нарт;</p>	<p>Тус аймгийн хэмжээнд өөр аймгаас шилжин ирж байгаа малын хөдөлгөөн харьцангуй бага байна. Малын шилжих хөдөлгөөнийг гарал үүслийн гэрчилгээг үндэслэн зохих журмын дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус аймгийн хэмжээнд 28 өрхийн 1322 толгой мал шилжин ирсэн байна. Тэмдэглэлийн хүрээнд тайланг ХХААХҮЯаманд хугацаанд нь хүргүүлж дүгнүүлсэн.</p>	2023 оны хаваржил тийн тайлаар тайланг хүргүүлэн хэрэгжүүлэн үнэлүүлсэн.
----	---------	--	---	---	--

ТАНИЛЦСАН:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ

ДАРГА

Б.АЗЖАРГАЛ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА П.БАЯРСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН